



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/75

Улаанбаатар хот

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Тавантолгойн цахилгаан станц төсөлд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн зарцуулалт түүний үр дүн”-д хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний яам, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банканд тус тус хүргүүлсүгэй

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2020 оны 12 дугаар 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний яам, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банканд тус тус зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/, Нийцлийн аудитын газар /С.Энхбаатар/-т даалгасугай.



Д.ЗАНДАНБАТ



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл	5
БҮЛЭГ 1. “ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ” ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ, ЗОРИЛГО ХАНГАГДААГҮЙ БАЙНА	
Гэрээний нэг тал болох ЭЗХЯ татан буугдсанаар талууд гэрээг шинэчлээгүй байна.....	6
Талууд гэрээний зорилгыг хангаагүй, гаргасан шийдвэрүүд уялдаагүй байна.....	7
Төслийн зээлийн эргэн төлөлтийн нөхцөлийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.....	8-9
БҮЛЭГ 2. ТӨСӨЛД ХӨГЖЛИЙН БАНКНААС ОЛГОСОН ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНГҮЙ БОЛОХ ЭРСДЭЛ БАЙНА	
Зээлийн санхүүжилтийг арвилан хэмнэлтгүй зарцуулж үр өгөөжгүй болох эрсдлийг үүсгэсэн байна.....	10
Төслийн нэгж бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-д нийцүүлж хэрэгжүүлээгүй байна.....	11
"Тавантолгойн цахилгаан станц" төслийн нэгж үндсэн зорилгоо зарим талаар хангаагүй, зээлийн зарцуулалт үр дүнгүй болох эрсдэл байна	12
ДҮГНЭЛТ	13
ЗӨВЛӨМЖ	14

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТТЦС	Тавантолгойн цахилгаан станц
ТТЦСТ	“Тавантолгойн цахилгаан станц” төсөл
ТТЦС ХХК	“Тавантолгойн цахилгаан станц” хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
ЭЗХЯ /хуучин нэрээр/	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдын 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн а/937 дугаартай “Аудитын дүгнэлт гаргуулах тухай” хүсэлтийг үндэслэн “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн зарцуулалт, түүний үр дүн”-д Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

“Тавантолгойн цахилгаан станц” төсөлд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн зарцуулалт, түүний үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг ил гаргаж мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн гэрээний нөхцөл холбогдох хууль, эрх зүйд нийцэж, гэрээний зорилго хангагдсан эсэх;
- “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн ашиглалт, зарцуулалт үр дүнтэй эсэх;

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитыг ТТЦС Төслийн нэгж, ЭХЯ, Сангийн яам, “Тавантолгой цахилгаан станц” ХХК, Хөгжлийн банк, ТТЦС барих төслийн нэгжийн 2013-2020 оны 1 дүгээр улирлын байдлаарх уг төсөлтэй холбоотой асуудлыг хамруулан гүйцэтгэлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг баримтлан төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон холбоотой талуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, тулган баталгаажуулах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль
- ЭЗХЯ /хуучнаар/, ЭХЯ, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан 3-ДЦ-Б 2014-09 дугаар бүхий “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”.
- ЭЗХЯ /хуучнаар/, Сангийн яам, Хөгжлийн банкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ:

Аудитын багийн гишүүд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн Үндэсний аудитын газарт ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг хянаж дүгнэлт гаргах “Ажлын хэсэг”-т ажилласан нь аудитын талбарын ажил эхлэх хугацаа хойшилсноос холбогдох байгууллагаас тайлбар тодруулга гаргуулах, тайлан боловсруулах зэрэгт цаг хугацааны хязгаарлалт үүссэн болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор¹ Засгийн газар үр ашиг бүхий томоохон төслүүдэд хөрөнгө оруулахаар олон улсын зах зээлд арилжсан бондын нийт 1.5 тэрбум ам.долларыг Хөгжлийн банкинд байршуулсан байна.

Дээрх хөрөнгийн эх үүсвэрээс Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай “Тавантолгойн цахилгаан станц” барих төсөл хэрэгжүүлэхээр 2013² онд Хөгжлийн банкнаас жилийн 6.1 хувийн хүүтэй 1.9 сая ам.долларын санхүүжилт олгох “Төсөл санхүүжүүлэх гэрээ”-г ЭЗХЯ, ЭХЯ, Хөгжлийн банк хооронд байгуулсан байна.

Уг гэрээний хугацаа дуусгавар болсноор Талууд 2014³ онд жилийн 6.1 хувийн хүүтэй, 2022 онд төлж дуусах нөхцөлтэй, 15.9 сая ам.долларын санхүүжих дүн бүхий “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ” байгуулжээ.

Хөгжлийн банк 2014 онд байгуулсан гэрээний дагуу олгосон 14.8 сая ам.доллароос өмнөх гэрээгээр санхүүжүүлсэн 1.9 сая ам.долларын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг суутган авсан байна.

Гэрээнд зээл олгосон өдрөөс эхлэн ашигласан бодит хоногоор хүүг тооцох, жилийн суурийг 360 хоног байх, зээлийн хүүгийн төлбөрийг 2015 оны 9 дүгээр сараас эхлэн хагас жил бүр төлөхөөр тусгажээ.

Зээлийн гэрээг Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал болон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан байна.

Гэрээнд төслийн бэлтгэл ажлын хүрээнд зээлийг мезанин⁴ нөхцөлд шилжүүлээгүй тохиолдолд ТТЦСТ-ийн зээлийн санхүүжилтийг дараах нөхцөлөөр эргэн төлөхөөр тусгажээ. Үүнд:

- Хөгжлийн банк нь зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлөгдөх,
- Зээлийг хуримтлагдсан хүүгийн хамт улсын төсөвт тусгуулан банкинд эргэн төлөх.

“Тавантолгойн цахилгаан станц” төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах эрх зүйн баримт бичгийг баримталж ажилласан байна. Үүнд:

- Засгийн газрын 2013 оны “Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 71 дүгээр тогтоол,,
- Засгийн газрын 2013 оны “Төсөл санхүүжүүлэх тухай” 80 дугаар тогтоол,
- Эрчим хүчний сайдын 2013 оны “Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах, ажилд томилох тухай” 36 дугаар тушаал,
- Эдийн засаг хөгжлийн сайдын 2013 оны “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах тухай” 29 дүгээр тушаалаар баталсан түр журам тус тус болно.

¹ “Эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5 тэрбум /таван тэрбум/ хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т зөвшөөрсүгэй

² 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Төсөл санхүүжүүлэх гэрээ” дугаар З-ДЦ-Б 2013-20

³ 2014 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ” дугаар З-ДЦ-Б 2014-09

⁴ Мезаниний санхүүжилт гэдэг нь компаниудад тодорхой төсөл хэрэгжүүлэх хөрөнгө босгох эсвэл эрлийз өр, хөрөнгийн санхүүжилтээр дамжуулан олж авах арга юм. Энэ төрлийн санхүүжилт нь ердийн корпорацын өртэй харьцуулахад илүү өгөөжтэй өгөөж өгдөг бөгөөд жилд 12-20 хувийн хооронд төлдөг.

БҮЛЭГ 1. “ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ” ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ, ЗОРИЛГО ХАНГАГДААГҮЙ БАЙНА

Гэрээний нэг тал болох ЭЗХЯ татан буугдсанаар гэрээ өөрчлөгдөх үндэслэл бий болсон байна

1.1. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай 2014 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Эдийн засгийн хөгжлийн яам татан буугдаж, Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээнд байсан улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудлыг Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд оруулсан байна.

1.2. Ийнхүү ЭЗХЯ нь эрх зүйн чадамжгүй болсноор нөхцөл байдал өөрчлөгдөж, талуудын хүсэл зоригоос үл хамааран гэрээгээр хүлээсэн эрх үүрэг⁵ эзэнгүйджээ. Тухайлбал,

- Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төслийн 2015-2020 оны нэгдүгээр улирлын байдлаар төслийн зардлын төсвийг ЭХЯ-ны ТНБД баталж, ТУХ-ны тогтоол шийдвэрээр ТТЦСТ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн байна.
- Мөн энэ асуудлаар Сангийн яаманд хүсэлт хүргүүлж байсан ч Сангийн яам уг төслийн зардлыг гадаадын зээл тусламжийн төсөл биш гэж тайлбарлан төсвийг батлаагүй байна. Энэ нь “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-ээр үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсныг харуулж байна.

1.3. ТТЦС төслийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулахаар ЭЗХС-ын 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн “Түр журам батлах тухай” 29 дүгээр тушаалаар “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг баталж, Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 116 дугаар тушаалаар хүчингүй болгох хүртэл хэрэгжүүлж иржээ.

1.4. Тус “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам” нь захиргааны хэм хэмжээний шинжтэй боловч улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй байна.

1.5. ЭЗХЯ татан буугдсан байхад дээрх хугацааны турш Талууд түр журмыг үйл ажиллагаандаа мөрдөж гэрээний үйлчлэлийг ойлгомжгүй хэлбэрээр үргэлжлүүлж ирсэн нь Иргэний хуулийн 15 дугаар бүлэг “Гэрээний эрх зүй”, болон бусад зохицуулалтад нийцэхгүй байна. Тухайлбал,

- Иргэний хуулийн 220 дугаар зүйлийн 220.3-т “Талууд өөрчлөгдсөн нөхцөл байдалд гэрээг зохицуулах арга хэмжээг тэргүүн ээлжид авах үүрэгтэй”
- Хуулийн 220 дугаар зүйлийн 220.4-т “Гэрээг өөрчлөгдсөн нөхцөл байдалд зохицуулах боломжгүй, эсхүл нөгөө тал нь зөвшөөрөөгүй бол эрх ашиг нь хөндөгдсөн тал гэрээнээс татгалзах эрхтэй”

Талууд гэрээний зорилгыг хангаагүй, гаргасан шийдвэрүүд уялдаагүй байна

1.6. Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн а/173 дугаар албан бичгээр “Тавантолгойн цахилгаан станц төслийн үйл ажиллагааны зардлыг ямар журам, аргачлалыг баримтлан зохицуулах талаар зөвлөмж чиглэл өгөх” хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

⁵ Гэрээний 6.1. ЭЗХЯ нь дараах үүрэгтэй:

6.1.1. Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс зээлийн эх үүсвэрийг Банканд байршуулах;
6.1.2. Зээлдэгчийн гаргасан саналыг харгалзан Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу батлах;
6.1.3. Гэрээний 3.1-д заасан нөхцөл хангагдаагүй тохиолдолд зээлийг хуримтлагдсан хүүгийн хамт улсын төсөвт тусгуулан Банканд эргэн төлнө;
6.1.4. Төслийн бэлтгэл ажил хангалттай хэрэгжээгүйн улмаас хөрөнгө бүрдүүлж чадаагүйгээс шалтгаалан зээлийг мезанин зээлийн нөхцөлд шилжүүлээгүй, эсхүл улсын төсвөөс эргэн төлөх боломжгүй болсон тохиолдолд Банк нь ЭЗХЯ, Сангийн яам, Хөгжлийн банкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний дагуу Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийг энэхүү зээл болон зээлийн хүүгийн нийт хэмжээгээр эргэн төлөх үүргээс Банкнийг чөлөөлнө.

6.2. ЭЗХЯ нь дараах эрхтэй:

6.2.1. Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал болон төслийн бэлтгэл үеийн зардлын зарцуулалтад хяналт тавих;
6.2.2. Төслийн хэрэгжилт, зээлийн зарцуулалтын талаарх мэдээллийг Төслийн нэгж болон Зээлдэгчээс шаардах.

1.7. Сангийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 8-1/692 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэхдээ “Засгийн газар болон Оюу толгой ХХК хооронд “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ”-г 2018 онд байгуулсантай холбогдуулан тус төслийн нэгжийг татан буулгах, төслийн хүрээнд хийсэн ажлыг Тавантолгойн цахилгаан станцыг барьж байгуулах дараагийн бүтцэд шилжүүлж, Монгол Улсын Хөгжлийн банкнаас авч ашигласан зээлийг Улсын төсөвт дарамтгүйгээр төлөх нөхцөлийг бүрдүүлж ажиллах”-ыг хүссэн байна.

1.8. Гэтэл “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээний 6.1.3-т зааснаар “Гэрээний 3.1-д заасан нөхцөл хангагдаагүй тохиолдолд зээлийг хуримтлагдсан хүүгийн хамт улсын төсөвт тусгуулан Банкинд эргэн төлнө” гэсэн үүргийг ЭЗХЯ хүлээсэн байх бөгөөд энэхүү үүрэг нь ЭЗХЯ татан буугдахад Сангийн яаманд шилжсэнд тооцогдохоор нөхцөл байдал үүссэн байна.

1.9. ТТЦСТ-ийн ТУХ нь “Хөрөнгөө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-д зааснаар өөрийн эрх, үүрэгт хамааралгүй зарим асуудлыг шийдвэрлэж иржээ. Тухайлбал,

- Журмын 6 дугаар зүйлийн 6.5.8⁶, 6.5.9⁷, 6.5.10⁸-д заасныг мөрдөж ажиллаагүй,
- Журмын 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Эдийн засгийн хөгжлийн яам нь төслийн нэгжийн орон тоо, цалин, түүний үйл ажиллагааны зардлыг батална” гэж заасны дагуу төслийн үйл ажиллагааны зардлын төсвийг 2013-2014 онд ЭЗХЯ баталсан, 2015 оноос ЭХЯ, ТУХ уг эрх үүргийг хэрэгжүүлсэн,
- Журмын 11.2-т Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг ТБОНӨХБАУХАТХ-д нийцүүлээгүй байдлаар зохицуулсан байна.

1.10. “Тавантолгойн цахилгаан станц” төслийн үйл ажиллагаанд хамаарах гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газар, ЭХЯ дараах тогтоол шийдвэрийг гаргасан байна. Тухайлбал,

- Засгийн газрын 2013 оны 80 дугаар тогтоол, “Тавантолгойн цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх тухай”
- Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 261 дүгээр тогтоолоор “Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төсөл”, ...-д олгосон санхүүжилтийн үлдэгдлийг Хөгжлийн банкнаас үргэлжлүүлэн үндсэн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, холбогдох гэрээг Эрчим хүчний яам, Хөгжлийн банкны хооронд шинэчлэн байгуулах тухай даалгасан,
- Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолоор “Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банкт байгуулсан холбогдох зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, дуусгавар болгох, баримт бичгийг хүлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан,
- Үүний дагуу ЭХЯ-ны ТНБД-ын 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 65 дугаар тушаалаар төсөл санхүүжүүлэх гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулсан,
- ЭХС-ын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 64 дүгээр тушаалаар Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа “Тавантолгойн цахилгаан станц” төслийн нэгжийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч цаашид авах арга хэмжээний санал боловсруулах “Ажлын хэсэг”-ийг байгуулжээ.

1.11. Гэвч дээрх тогтоол шийдвэрийн биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй, гэрээг дүгнээгүй, эрх үүргийг шилжүүлээгүй, гэрээний хэрэгжилтийг хэрхэн хангуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

1.12. Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн “Тавантолгой цахилгаан станц”-ын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний

⁶ТУХ-ын чиг үүрэгт тусгагдаагүй

⁷ТУХ нь төслийн нэгжийн цалин, үйл ажиллагааны зардлыг батлахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхгүй.

⁸Үнэт цаасны хөрөнгөөр нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах асуудлыг Хөгжлийн банк, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, ЭЗХЯ-д танилцуулж шийдвэрлүүлэх

тухай” 124 дүгээр тогтоолын 1 дүгээрт “Тавантолгой цахилгаан станц” ХХК-ийг байгуулах, 2 дугаарт компанийн үйл ажиллагааны зардал болон төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Сангийн сайд, Эрдэнэс тавантолгой ХК-ийн ТУЗ-д тус тус даалгасан байна.

1.13. Гэвч одоогийн байдлаар ТТЦС барих нөхцөл бүрдээгүй, гүйцэтгэгч тодорхойгүй, цахилгаан станц барих зураг төсөл бэлэн бус, төслийн чиглэлээр өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөөгүй нь цаашид цаг хугацаа, санхүүгийн эрсдэл үүсгэж болзошгүй байна.

1.14. Нөгөө талаас зээлдүүлэгч Хөгжлийн банк нь “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль”, Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 07 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал,

- Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газраас 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Зээлийн саналд хийсэн эрсдэлийн дүгнэлтээр “ТТЦС-төслийн үйл ажиллагааны бэлтгэл ажилд зориулан олгох зээлийн санхүүжилтийг эрсдэлтэй гэж үзсэн”
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу дотоод аудитын нэгж нь ТУЗ-өөс баталсан шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, зөвлөмж өгөх чиг үүргийг хэрэгжүүлээгүй,
- Түүнчлэн уг хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2-т заасны дагуу тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийгээгүй,
- ТТЦСТ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зээлийн санхүүжилтийг олгох хууль зүйн үндэслэлтэй эсэхэд 2013-2017 онд нийт 6 удаа хууль зүйн дүгнэлт гаргуулж байсан боловч дүгнэлтийн мөрөөр арга хэмжээ аваагүй байна.

1.15. Ийнхүү төслийн талаар гаргасан шийдвэрүүд уялдаагүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй, маргаан бүхий нөхцөл байдал үүссэн боловч Талууд өнөөг хүртэл хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаарх гэрээний холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төслийн зээлийн эргэн төлөлтийн нөхцөлийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна

1.16. “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээ байгуулахаас өмнө Хөгжлийн банкны Зээлийн хорооны 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрээр зээл олгох нөхцөл, эргэн төлөлтийн тухай асуудлыг Хөгжлийн банкны ТУЗ-д дараах хувилбараар танилцуулсан байна. Үүнд:

- Хувилбар 1: Хөгжлийн банк, ЭЗХЯ, Сангийн яамны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний 4.1.3⁹-т заасны дагуу Хөгжлийн банк нь Чингис бондын эргэн төлөлтөөс чөлөөлөгдөх,
- Хувилбар 2: Засгийн газрын холбогдох тогтоол гаргуулан Улсын төсвөөс эргэн төлүүлэх.

1.17. Гэвч зээлийн эргэн төлөлтийн нөхцөлд дээрх 2 хувилбарыг шууд тусгасан нь Талууд тухайн нөхцөлийн талаар харилцан тохиролцсон эсэх, нэгдмэл санаа зорилгод хүрч гэрээг байгуулсан эсэх нь тодорхойгүй байна.

1.18. Дээрх байдлаар зээлийн эргэн төлөлтийн нөхцөлийг гэрээнд тусгаж оруулсан нь Хөгжлийн банкныг зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлөх, Улсын төсвөөс зээлийг эргэн төлүүлэх эрх үүргийг баталгаажуулсан байна.

1.19. Энэ нь гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтан гэрээний үр дагаврыг тооцоолоогүй, улсын төсөвт өр үүсгэх эрсдэл бүхий харилцааг гэрээгээр хүлээн зөвшөөрсөн нь өөрт олгосон эрх мэдлийн хязгаараас давсан байж болзошгүй байна.

⁹ Гэрээний 2.4-д заасны дагуу санхүүжүүлсэн төслөөс үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөөгүй нөхцөлд энэхүү төлөгдөөгүй дүнгээр Гэрээний 4.2.2 болон төлөгдөөгүй дүнд ногдох хүүгийн хэмжээгээр 4.2.3-д заасан үүргийг хангахгүй байх.

1.20. Төсөлд Хөгжлийн банкнаас олгосон зээлийн хүүгийн зардлыг үндсэн зээлээс төлөх зохицуулалтыг гэрээгээр харилцан тохиролцоогүй, зээлийн төлбөрийг харилцах данснаас үл маргах журмаар суутган авч байгаа нь үндэслэлгүй байна. Тухайлбал,

- Гэрээний 3.4-т “Зээлийн хүүгийн төлбөрийг Гэрээний хавсралт 1-д заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2015 оны 3 дүгээр сараас эхлэн хагас жил бүр төлнө” гэж зээлдэгч гэрээнд заасан хугацаанд хүүг буцаан төлөх үүргийг хүлээсэн байна.
- Хөгжлийн банкны 2017 оны 2017/15 дугаартай дүгнэлтэд зээл, түүний хүүг төлөх хугацаа болсон өр төлбөрийг суутган авч төлүүлэх нь хууль зүйн хувьд боломжтой гэжээ.

1.21. Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд 15.9 сая ам.долларын зээл олгох шийдвэрийн дагуу Хөгжлийн Банкн дахь 3600000760 дугаартай ам.долларын зээлийн данснаас ЭХЯ-ны төслийн 3600000254 дүгээр харилцах дансанд 14.8 сая ам.долларыг шилжүүлсэн байна.

1.22. Гэрээнд зээлийн хүүгийн төлбөрийг 2015 оны 9 дүгээр сараас эхлэн хагас жил бүр төлөхөөр эргэн төлөлтийн хуваарийг хийсэн байна.

1.23. Хуваарийн дагуу 2014 онд олгосон 14.8 сая ам.долларын зээлийн 2015, 2016 оны хүүгийн төлбөрт 2.4 сая ам.долларыг улсын төсвөөс буюу Сангийн яам төлсөн нь гэрээ болон хуульд нийцээгүй бөгөөд Сангийн яам зээлийн хүүг төлсөн талаарх шийдвэрийг аудитын явцад гаргаж өгөөгүй болно.

1.24. УИХ-ын 2016 оны 81¹⁰, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 441 дүгээр тушаалаар Засгийн газар, Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгал хийхийг эцэслэн шийдвэрлэсний дагуу ЭХЯ-ны төслийн харилцах данснаас Сангийн яаманд 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 2.4 сая ам долларын хүүгийн зардлыг буцаан шилжүүлсэн байна.

1.25. Зээлдэгч хууль, гэрээнд заасны дагуу зээлийн үндсэн төлбөр, хүүг буцаан төлөх үүрэгтэй байна.

1.26. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 24¹¹ дүгээр зүйлд заасны дагуу Хөгжлийн банк нь олгосон зээлд судалгаа хийж ангилаагүй, холбогдох гэрээгээр харилцан тохиролцоогүйгээр хүүгийн төлбөрийг зээлийн санхүүжилтээс суутган авсан, гэрээнд заасан санхүүжилтийн үлдэгдэл 1.1 сая ам.долларыг олгоогүй зэрэг нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна.

1.27. Гэрээнд оролцогч талууд гэрээний гол нөхцөлүүдийн талаар нэгдмэл санаа зорилгод хүрч харилцан тохиролцож байгуулсан эсэх нь эргэлзээтэй, тодорхойгүй байдал нь төсөл хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж, маргаан бүхий үл ойлголцол үүсэх нөхцөл бүрджээ.

1.28. Энэ талаар гэрээнд оролцогч талууд “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-ний 7.4¹² -т заасны дагуу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх, зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлүүлэх боломжтой байна.

¹⁰ “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.1-д “Монгол Улсын Засгийн газар, МУХБ хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгах замаар эцэслэн шийдвэрлэж, МУХБ-ны зохистой харьцааны холбогдох шалгуур үзүүлэлтийг сайжруулах.”

¹¹ Хуулийн 24.1. Зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнэ нь зээлийн хүү болно.

¹² Гэрээний 7.4 “Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарах маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ”

БҮЛЭГ 2. ТӨСӨЛД ХӨГЖЛИЙН БАНКНААС ОЛГОСОН ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНГҮЙ БОЛОХ ЭРСДЭЛ БАЙНА

Зээлийн санхүүжилтийг арвилан хэмнэлтгүй зарцуулж, үр өгөөжгүй болох эрсдэлийг үүсгэсэн байна

2.1. ТТЦСТ-д нийт 14.8 сая ам.долларын зээл олгосноос 2014-2020 оны эхний улирлын байдлаар 95.8 хувь буюу 14.2 сая ам.долларын зээлийг зарцуулжээ. Үүнээс зээлийн хүүгийн зардалд 38.0 хувь буюу 5.6 сая ам.доллар, төслийн нэгжийн үйл ажиллагаанд 46.4 хувь буюу 6.5 сая ам.долларыг тус тус зарцуулсан байна.

2.2. 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хөгжлийн банкин дахь ЭХЯ-ны харилцах дансанд 0.6 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

ТТЦСТ-ийн зээлийн зарцуулалтын судалгаа

Зээлийн зарцуулалт	Дүн /мянган ам.доллар/	Эзлэх хувь
Олгосон зээл:	14,816.2	
Зээлийн зарцуулалт	14,200.0	95.8
Зээлийн хүү	5,623.9	38.0
Зээлийн эргэн төлөлт	1,985.7	13.4
Төслийн үйл ажиллагаанд:	6,590.4	46.4
Төслийн нэгжийн цалин	1,610.0	24.4
Төслийн нэгжийн томилолт	460.0	7.0
Олон улсын зөвлөх үйлчилгээ	2,880.0	43.7
Дотоодын зөвлөх болон судалгаа	500.0	7.6
Төслийн удирдах хорооны зардал	50.0	0.8
Бусад зардал	1,090.4	16.5



2.3. Хүснэгтээс үзвэл, Төслийн үйл ажиллагааны зардлаас олон улсын зөвлөх үйлчилгээнд 2.9 сая, цалингийн зардалд 1.6 сая, шуудан холбоо, бичиг хэрэг, байрны түрээс, тээврийн хэрэгсэл, хангамжийн материал зэрэгт 1.1 сая, төслийн нэгжийн томилолтын зардал болон дотоодын зөвлөх үйлчилгээ, судалгаа, ТУХ-ны зардалд нийт 1.0 сая ам.долларыг тус тус зарцуулжээ.

2.4. ТТЦСТ-ийн нэгж зээлийн санхүүжилтийг захиран зарцуулсан боловч зээлийг эргэн төлөх субъект тодорхойгүй, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад шийдвэрийн уялдаа холбоогүй байдал цаашид төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэх ойлгомжгүй нөхцөлийг үүсгэсэн байна.

Төслийн нэгж бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-д нийцүүлж хэрэгжүүлээгүй байна

2.5. Төслийн худалдан авах үйл ажиллагаанд зарцуулсан 3.4 сая ам.доллар буюу 51.3 хувийг ЭЗХС-ын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан түр журам, ТУХ-ны тогтоолыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалт явуулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулжээ.

2.6. Дээрх журам, тогтоол нь хууль тогтоомж шууд зөрчөөгүй ч хуулиас гадуур зохицуулалттай хэм хэмжээний акт байх бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мөрдөж ажиллахад учир дутагдалтай байна. Тухайлбал,

- Хязгаарлагдмал сонгон шалгаруулалтын аргыг хэрэглэх талаар тусгаагүй;
- Харьцуулалтын аргыг хэн, хэрхэн хэрэглэх талаар зохицуулсан зохицуулалт байхгүй;
- Худалдан авах гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийн талаар тусгаагүй;

- Нээлттэй сонгон шалгаруулалтын тендерийн баримт бичгийг ажлын хэсэг, тухайн ажил хариуцсан нэгж, ажилтны аль нь боловсруулах нь тодорхойгүй;
- Тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулах зохицуулалт тусгаадаагүй;
- Шаардлагад нийцсэн бүх сонгон шалгаруулалтын үнэ батлагдсан төсвөөс хэдэн хувь хэтэрсэн тохиолдолд бүх сонгон шалгаруулалтын материалаас татгалзах нь тодорхойгүй;
- Худалдан авах ажиллагаанд Дотоод хяналт, шалгалтын нэгжийн хяналт хэрхэн хэрэгжих талаар тодорхойлсон зохицуулалтгүй;

2.7. Иймд шууд болон харьцуулалтын аргаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гэрээнд урьдчилгаа төлбөрийг хэрхэн олгох талаар зохицуулалт байхгүйгээс дийлэнх гэрээнүүд гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 70 хувийн урьдчилгаа төлбөр төлөх, захиалагчид актаар хүлээлгэн өгсний дараа үлдэгдэл 30 хувийг төлөх нөхцөлтэй хийгдсэн байгаа нь санхүүжилттэй уялдуулан гэрээний хэрэгжилтийг хангуулах боломжгүй болох эрсдэлийг үүсгэжээ.

“Тавантолгойн цахилгаан станц” төслийн нэгж үндсэн зорилгоо зарим талаар хангаагүй, зээлийн зарцуулалт үр дүнгүй болох эрсдэл байна

2.8. ЭХЯ болон ТТЦСТ-ийн нэгжээс Хөгжлийн банкны ТУЗ-д танилцуулсан төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд “Гадны хөрөнгө оруулагчийг шийдвэрлэх хугацааг 2014 оны 8 дугаар сар, санхүүгийн бүрдлийг хангах хугацааг 2015 оны 1 дүгээр улирал, барилга угсралтын ажлыг эхлүүлж нэгдүгээр блокийг ашиглалтад оруулах хугацааг 2017 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэх” гэж төлөвлөсөн байна.

2.9. ТТЦС төслийн гадаадын хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулалтад 3 компанийн ирүүлсэн саналыг үнэлж ТТЦС ТУХ-ны 2016 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоолоор “Тавантолгой цахилгаан станц” төслийн гадаадын хөрөнгө оруулагчаар Япон Улсын “Марубени” корпорацийг шалгаруулсан байна.

2.10. Гэвч 2017 оны 4 дүгээр сард “Марубени” компани “... эрчим хүч худалдан авах хэрэглэгчийн баталгааны талаарх асуудал уг төсөл эхэлснээс хойш 4 жилийн хугацаа өнгөрсөн боловч тодорхой болоогүй тул ТТЦС төсөлд үргэлжлүүлэн хамтран ажиллах боломжгүй тухай” шийдвэр гаргаж, төслийн гадаад хөрөнгө оруулагчаас татгалзсан байна.

2.11. Тавантолгойн цахилгаан станц баригдаж дууссаны дараа түүний гаргах цахилгаан эрчим хүчийг худалдан авах голлох хэрэглэгчийн баталгааг тус цахилгаан станцыг барих хөрөнгө оруулагчид гаргаж өгөөгүй тохиолдолд цаашид ч гадаадын хөрөнгө оруулагч нар тус төслийг хэрэгжүүлэхээр орж ирэхгүй байхаар байна.

2.12. Улмаар ТТЦСТ-ийн нэгж зээлийн санхүүжилтээр үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулж ирсэн боловч гадаадын хөрөнгө оруулагч шалгаруулж, гэрээ байгуулах үндсэн зорилгоо хэрэгжүүлж чадаагүй буюу олон улсын зөвлөх үйлчилгээнд зарцуулсан 2.9 сая ам.долларын зардал гарсан нь үр дүнгүй болох эрсдэл үүссэн байна. Тухайлбал,

- Төслийн нэгж нь олон улсын банк, санхүүгийн байгууллагад зориулж гадаадын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцын:
 - ТЭЗҮ-ийг төслийн техникийн зөвлөх болох “WorleyParsons” компаниар 0.6 сая ам.доллар /1.6 тэрбум төгрөг/-р 2015 онд хийж гүйцэтгүүлсэн байна,
 - Олон улсын санхүүгийн зөвлөх үйлчилгээг “Sumitomo Mitsui bank”-аар 1.1 сая ам.доллар /2.6 тэрбум төгрөг/,
 - Олон улсын Хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээг “Shearmansterling” компаниар 0.9 сая ам.доллар /2.0 тэрбум төгрөг/,
 - Байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийн олон улсын зөвлөх үйлчилгээг “Mott MacDonald” компанид 0.3 сая ам.доллар /0.8 тэрбум төгрөг/-ийг тус тус зарцуулсан байна.

2.13. Харин Эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн туршлага, санхүүгийн чадавх зэрэгт үндэслэн ТТЦС ТУХ-ны 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Тавантолгой цахилгаан станц” төслийн дотоодын хөрөнгө оруулагчаар “М-Си-Эс Холдинг” ХХК /ТТЦС ХХК/-ийг сонгон шалгаруулсан байна.

2.14. Төслийн дотоодын хөрөнгө оруулагч М-Си-Эс групп /ТТЦС ХХК/ нь 2013-2019 онд ТТЦС-ийн төсөлд зориулж нийт 7.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж аудитад өгсөн тайлбар, тодруулгад ирүүлсэн байна.

2.15. Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн “Тавантолгойн цахилгаан станц”-ын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 124 дүгээр тогтоолын 1 дүгээрт “Тавантолгой цахилгаан станц” ХХК-ийг байгуулах, 2 дугаарт компанийн үйл ажиллагааны зардал болон төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Сангийн сайд, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-д тус тус даалгажээ.

2.16. Гэвч одоогийн байдлаар ТТЦС барих нөхцөл бүрдээгүй, гүйцэтгэгч тодорхойгүй, цахилгаан станц барих зураг төсөл бэлэн бус, төслийн чиглэлээр өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөөгүй нь цаашид цаг хугацаа, санхүүгийн эрсдэл үүсгэхээр байна.

2.17. Түүнчлэн “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт санхүүжилт бүрдүүлэхгүй, гадаадын хөрөнгө оруулагчийг татан оролцуулахгүй нөхцөлд төслийн олон улсын зөвлөх үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө оруулалт, бүрдүүлсэн баримт бичиг үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоол “УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай”-ын хүрээнд “Тавантолгойн цахилгаан станц” төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ЭХЯ, Сангийн яам, Хөгжлийн банкны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ЭХЯ, Хөгжлийн банкны хооронд хийгдэх гэрээний төсөл боловсруулах, өмнө байгуулсан “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээг дүгнэх ажлууд хийгдсэн боловч хэрэгжилт хангалтгүй, тодорхой шийдвэр гаргаагүйгээс гэрээ хүчин төгөлдөр хэвээр үргэлжлэн зээлийн эргэн төлөлт гэрээнд заасны дагуу улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөл байдал үүссэн байна.
2. “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээний зорилго биелэгдээгүй, төслийн нэгжийн үйл ажиллагаа зарим талаар хангалтгүй, зээлийн санхүүжилтээс 2.9 сая ам.долларын зардлыг үр өгөөжгүй болгож, ЭЗХЯ татан буугдаж гэрээгээр хүлээсэн үүрэг нь Сангийн яаманд шилжсэнд тооцогдохоор байхад гэрээний талууд зөвшилцөлд хүрэхийг эрмэлзээгүй, гэрээний хэрэгжилт хяналтгүй, хариуцлага алдсантай холбоотой байна.
3. Талууд гэрээнд зайлшгүй тусгавал зохих зээлийн хүүгийн эргэн төлөлтийг бодитой хэрэгжихээр тусгаагүйгээс Хөгжлийн банк “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд олгосон 14.8 сая ам.долларын зээлийн хүүгийн эргэн төлөлтийг зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар суутган авч маргаан бүхий нөхцөл байдлыг үүсгэсэн нь Иргэний хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад хуулиар зохицуулах хэм хэмжээнд нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Л.Оюун-Эрдэнэ/-т:

- Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/-д:

- Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, Хөгжлийн банк, ЭХЯ, ЭЗХЯ-тай байгуулсан “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гурван талт зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, эсхүл дуусгавар болгох ажлыг зохион байгуулж, чиг үүргийн дагуу Эрчим хүчний сайд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран уг төслийн зээлийн эргэн төлөлтийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах.

Эрчим хүчний сайд /Н.Тавинбэх/-д:

- “Тавантолгойн цахилгаан станц” төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээний талуудтай харилцан зөвшилцөлд хүрэх, гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах.

Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхсүх/-д:

- “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-ээс үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйл ажиллагааг дэмжих, талууд нэгдмэл санаа зорилгод хүрч, гэрээг шинэчлэх, өөрчлөх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, spanning the width of the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.